



ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: ДНБ, УЛСЫН ТӨСӨВ, ГАДААД ХУДАЛДАА, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ

Эдийн засгийн өсөлт 2014 оны эхний хагас жилийн байдлаар 5.3% ДНБ-ий өсөлт 2010 оны зэрэгцүүлэх үнээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 нэгж хувиар буурч 5.3% болсноор 5.7 их наяд төгрөгт хүрэв. Харин оны үнээр өсөлттэй гарахад хөдөө аж ахуйн салбар 16.3%, аж үйлдвэр, барилгын салбар 10.1% өссөн нь голлон нөлөөлсөн харин бусад салбарын өсөлт удааширсан нь өсөлтийн хурдыг харьцангуй саарахад нөлөөлсөн байна.




Улсын нэгдсэн төсвийн алдагдал

2014 оны эхний 9-р сарын байдлаар улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл дэх төсвийн алдагдал 192 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн жилээс 47.1 хувиар өссөн байна. Үүнд улсын нэгдсэн төсвийн нийт зарлага өнгөрсөн жилээс 10.7 хувиар өсч 4.5 их наяд төгрөгт хүрсэн нөлөөлсөн байна. Харин нийт тэнцвэржүүлсэн орлого 9.5 хувиар өсч 4.31 их наяд төгрөг болов. Тайлант сард төсвийн орлого өнгөрсөн 8-р сараас хассан зөрүү 513 тэрбум төгрөг болж өнгөрсөн сараас 4.2 хувиар өссөн байна. Төсвийн зарлага мөн өссөлттэй гарч өнгөрсөн сараас 14.1 хувиар өссөн байна.



Гадаад худалдааны алдагдал 24 сая ам.доллар болж буурав.

Импорт өнгөрсөн жилээс 16.1 хувиар буурч 4.05 тэрбум ам.доллар, экспорт өнгөрсөн жилээс 29.8 хувиар өсч 4.02 тэрбум ам.доллар болсон байна. Гадаад худалдааны нийт эргэлт өнгөрсөн оны 9-р сараас 1.8 хувиар өсч 8 тэрбум ам.доллар болсон байна. Тухайн тайлант сард өнгөрсөн 8 сарын өсөлтөөс гадаад худалдааны экспорт 29.9 хувиар, импорт 0,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гадаад худалдааны экспортын орлого өнгөрсөн жилээс өссөн шалтгаанд жин их эзэлдэг эрдэс бүтээгдэхүүн нөлөөлсөн байгаа бол импортын өнгөрсөн жилээс 16.1 хувиар буурахад машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, зурагт, тэдгээрийн сэлбэг гэх зэрэг хүчин зүйлс нөлөөлж байна.



Валютын ханш эргээд тогтворжих хандлагатай байна.


Төв банкнаас мөнгөний хатуу бодлого явуулсан нь үр дүнгээ өгч 9-р сарын төгрөгтэй харьцах ам.долларын ханш өнгөрсөн сараас 1.4 хувиар буурч 1835.75 төгрөгт хүрчээ. Гэхдээ ханшийн сулрал хараахан арилагүй байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 10.4 хувиар, 2014 оны эхэн үеэс 9.6 хувиар мөн 3-р улиралд 0.6 хувиар ам.долларын ханш суларсан үзэгдэл хэвээрээ байна.



Гадаад валютын нийт албан нөөц 2014 оны 8-сарын байдлаар өнгөрсөн сараас 0.8 хувиар өсч, оны эхэн үеэс 39.5 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 50.1 хувиар буурч 1361 сая ам.долларт хүрсэн байна.

Инфляци 13 хувь болж буурав.

Хэрэглээний үнийн улсын индекс буюу инфляци нь өнгөрсөн жилээс 0.7 хувиар буурч 13 болов. Энэ оны 9-р сарын үнийн ерөнхий индекс өнгөрсөн сартай харьцуулахад 0.3 хувиар өсч 0.7 хувь болсон байна. Энэ сарын үнийн ерөнхий индексийн өөрчлөлтөнд орон сууц, ус цахилгаан, түлш, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны үнийн өсөлтүүд голлох нөлөөлөгч хүчин зүйлсүүд болсон байна.




САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 10.07 их наяд төгрөг болсон байна.

Мөнгөний нийлүүлэлт өнгөрсөн сараас 0.6 хувиар буурч, жилийн өөрчлөлт 18.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өнгөрсөн сарын өөрчлөлтөнд гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн нь өнгөрсөн сараас 6 хувиар буурч 827 тэрбум төгрөгт хүрсэн байна.




Төгрөгийн хадгаламж буурсан хэвээрээ байна.

Улсын нийт хадгаламжийн хэмжээ 3.3 хувиар буурч 6.7 их наяд төгрөгт хүрэв. Энэхүү бууралт нь төгрөгийн хадгаламж шууд хамаарч өнгөрсөн сараас 4.3 хувиар буурч 5.2 их наяд төгрөг болж нөлөөлсөн байна. Улсын нийт хадгаламжийн 22.5 хувийг гадаад валютын хадгаламж эзэлж байна. Гадаад валютын өөрчлөлт өнгөрсөн сараас 0.1 хувиар өсч 1.5 их наяд төгрөг болсон байна. Төгрөгийн хадгаламжийн хүү өнгөрсөн оны мөн үеэс 1.7 хувиар өсч 12.3 болсон.



Чанаргүй зээлийн хэмжээ буурсан байна.

Чанаргүй зээлийн хэмжээ 590 тэрбум төгрөг болж өнгөрсөн сараас 4.8 хувиар буурч жилийн өөрчлөлт 9.9 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн сараас 2.2 хувиар, өнгөрсөн жилийн мөн үеэс 24.2 хувиар тус тус өсч 12.6 их наяд төгрөг болсон байна. Төгрөгийн зээлийн хүү өнгөрсөн сараас 6.6 хувиар буурч, өнгөрсөн оноос 3.7 хувиар мөн буурч 18.3 болсон бол гадаад валютын зээлийн хүү өнгөрсөн сараас 2.2 хувиар өсч, өнгөрсөн оны мөн үеэс 14 хувиар буурч 13.8 болсон.



Эх сурвалж: УЦХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > ОХУ-ын ерөнхийлөгч В. В. Путин 2014 оны 9-р сарын 3,4 нд Монгол улсад айлчлал хийв.
- > ОХУ-ын "Роснефть" компани Монголоос 1000 оюутныг газрын тос инженер зэрэг нарийн мэргэжлээр сургахаар болжээ.
- > Монгол Улсын өргөмжит консулуудын зөвлөлдөх уулзалт энэ сарын 17-ны өдөр болов. Хамгийн анх 1992 онд Хонконгийн иргэн Квок Шүминийг Монголын анхны өргөмжит консулаар томилсноор эхлэл тавигдаж байжээ. Өнөөдөр дэлхийн 44 орны 72 иргэн Монголын өргөмжит консулаар ажиллаж байгаа аж.
- > Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтын 2014-2015 оны Дэлхийн өрсөлдөх чадварын тухай илтгэлийг энэ сард танилцууллаа. Илтгэлд Монгол Улсын энэ оны байдлаар өрсөлдөх чадварын үзүүлэлтээрээ өнгөрсөн оноос өсөн байраар урагшилж нийт 144 орноос 98 дугаар байранд эрэмблэгдсэн байна.

Хураангуй

2014 оны 9-р сарын байдлаар Монгол Улсын макро эдийн засгийн гадаад, дотоод орчин тааруухан байгаа хэвээр байна. Дотоод орчин: Дотоодын мөнгөн тэмдэгтийн ханшийн ерөнхий хандлага унасан хэвээр байна. Гэвч тайлант сард өнгөрсөн сараас 1.4 хувиар буурч 1835.8 төгрөг болсон нь төвбанкны зүгээс хэрэгжүүлж буй мөнгөний хумих бодлого нөлөөлсөн байна. Үүнийгээ дагаад төгрөгийн ханш тогтворжих хандлагатай байна. Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх 888 төслийн хүрээнд хэд хэдэн үйлдвэрүүд ашиглалтанд ороод байна. Тухайлбал, дотоодын гутлын хэрэгцээний гутлын 30 хувийг хангах хүчин чадалтай "Best shoes" үйлдвэр ашиглалтанд оров. Мөн Чингис бондоор санхүүжигдсэн Хөвсгөл, Сүхбаатар, Өмнөговь аймгуудыг нийслэлтэй хатуу хучилттай замаар холбох ажил дууссан байна. Гадаад орчин: Монгол улсын засгийн газар Чингис, Самурай, Хөгжлийн банкны зэрэг бондуудыг гаргасан. Эдгээр бондуудын эхний төлбөр болох Чингис бондын 0.5 тэрбум ам.долларын төлбөрийг 2018 онд төлөх ёстой билээ. Өнөөгийн байдлаар энэхүү төлбөрийг хэрхэн төлөх нь тодорхойгүй байна. Уг төлбөрийг улсын төсвөөс төлөх учиртай билээ. Гэвч улсын төсөв алдагдалтай буюу төсвийн орлогын бүрдэлт төлөвлөсөн хэмжээнд хүрэхгүй байна. Мөн төвбанкны гадаад валютын албан нөөц эрс буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт буурснаар төлбөрийн тэнцэл алдагдалтай гарч байна. Үүнээс гадна Монгол улсын Олон улсын зээлжих зэрэглэл буурснаар Монгол улс дахин зээл авах, бонд босгоно гэдэг үнэхээр хэцүү болж байна. Оюутолгойн далд уурхайн санхүүжилт орж ирэхгүй удаж байгаа нь валютын ханш цаашид улам өсөх эрсдлийг мөн дагуулж байна.



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2014 оны IX сар



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2014 оны IX сар



САР ТУТМЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

2014 оны IX сар